



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 162

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Баруун бүсийн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 150,000,000.00 (нэг зуун тавин сая) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан автомашиныг данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. "Баруун бүсийн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Р.Нямтуул, Увс аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга М.Улаанхүү нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан автомашиныг данснаас хасах, хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулах;

2.2. Хавсралтад заасан автомашиныг засаж сэлбэн, орон нутгийн өмчит хуулийн этгээдэд эзэмшүүлэх, ашиглуулах, бүртгэх ажлыг зохион байгуулах;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Автомашины улсын дугаарыг шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс /Д.Нарангэрэл/-т үүрэг болгосугай.

ДАРГА


З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРАНГЭРЭЛ



000120


 Төрийн өмчийн бодлого,
 зохицуулалтын газрын 2020 оны 04
 дүгээр сарын 21-ны өдрийн 1.662
 ТООТ ТОГТООЛЫН ХАВСРАЛТ

"Баруун бүсийн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн балансаас хасах хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглал тад орсон он	Тоо шир хэг	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Нийт үнэ /төгрөгөөр/	Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Үлдэх өртөг /төгрөг/
1	Тоёото Ландкрузер-200 маркийн, УБҮ 99-26 улсын дугаартай, арлын дугаар-ЈТМНХ05Ј404022091, суудлын автомашин	2010	1	150,000,000.00	150,000,000.00	150,000,000.00	0.00
			1 (нэг)		150,000,000.00 (нэг зуун тавин сая)	150,000,000.00 (нэг зуун тавин сая)	